

## FICHE EXPLICATIVE RADIOGRAPHIE THORACIQUE EN MONGOL



Та цацраг эмчилгээ оношлогооны тасагт ирэнгээ манай туслах ажилтанд хандан түүнд өөрийн жороо үзүүлэн, өөрийн эрүүл мэндийн даатгалын баримт бичгийг (CMU, AME) үзүүлнэ үү.

Туслах ажилтан таныг хүлээлтийн өрөөнд хүлээлгэн дараа нь уушгины рентген зураг авахаар дуудна.

### Үзлэгийн ерөнхий явц

Танд зааж өгсөн тасалгаанд орох;

Цээжээ нүцгэн байлгах ;

Эмэгтэйчүүд хөхний даруулгаа тайлах;

Ямар нэгэн гоел чимэглэл байвал тайлах ( хүзүүний зүүлт, ээмэг, цаг, бөгж г.м.)

Тасалгаанд хүлээх;

Цацрагийн техникч мэргэжилтэн (рентген зургийг авах ажилтан) тантай уулзангаа уг аппаратыг таны цээжний өмнө байрлуулна (байрлал нь бага зэрэг эвгүй). Зааж өгсөн биеийн байдлыг хадгалах нь маш чухал.

Уушгины рентген зураг авах явц нь цацрагийн техникч мэргэжилтний зааснаар 3 үе шаттай явагдана :

**Нэгдүгээр үе шат** = Уушгаа бүх чадлаар нээх, гүнзгий амьсгалах

**Хоёрдугаар үе шат** = Амьсгалаа 5 секундын дотор хураах

**Гуравдугаар үе шат** = Хэвийн байдлаар амьсгалах

Үзлэгийн дараа хувцсаа тайлсан тасалгаанд буцан ороорой. Уг тасалгаандаа цацрагийн техникч мэргэжилтэн зургийг шалгатал хүлээх хэрэгтэй (чанаргүй гарсан тохиолдолд давтан зураг авна).

Хэрэв зураг үнэн зөв гарсан тохиолдолд хувцсаа өмсөнө үү.

Хүлээлтийн өрөөнд уушгины рентген зургийг танд гардуулан өгөхийг хүлээнэ үү.

Уушгины рентген зургийг цаашид өөртөө хадгалах нь чухал, яагаад вэ гэвэл ирээдүйд давтан уушгины рентген зураг авах тохиолдолд харьцуулж оношлох шаардлага гарч ирэх магадлал өндөр байдаг